

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 _{оны} 09 _{сарын} 0/ _{едер}

Дугаар \$ 1544

Арвайхээр сум

Зардал хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/02 дугаар тогтоолоор батлагдсан "Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 3.2.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Аймгийн 2023 оны төсөв батлах" 07/08 дугаар тогтоолын тавдугаар хавсралтын 11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1. "Аймгийн 2023 оны төсөв батлах" 07/08 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын 11 дэх заалтад тусгагдсан "Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төрөх эмнэлгийн дулаан, бохир усны шугамын засвар" хийх төсөл арга хэмжээний зардал 200,000,000 (хоёр зуун сая) төгрөгийг хавсралтад зааснаар зарцуулсугай.
- 2.Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газар (З.Балданням)-т даалгасугай.
- 3.Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

үүрэг гүйцэтгэг



и.доржсүрэн

Аймгийн Засаг даргын 2023 оныдугаар сарын.....-ны өдрийндугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

Nº	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг (төг)
1	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төрөх эмнэлгийн дулаан, бохир усны шугамын засвар	154,455,739
2	Бүрд сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны дээврийн засвар	45,544,261
Нийт дүн		200,000,000